

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 7679 дүгээрт бүртгэв

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 8 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар А/794

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, 2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох, хяналт тавих журам”-ыг нэгдүгээр, мод бэлтгэх цахим эрхийн бичгийн загварыг хоёрдугаар, мод, модон материал тээвэрлэх цахим гарал үүслийн гэрчилгээний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар (Б.Оюунсанаа), Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газар (Ц.Уранчимэг), Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллахыг Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газар (Т.Балжинням)-т даалгасугай.

4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/692 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД

Ц.САНДАГ-ОЧИР

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын
2026 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн
А/794 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт*

МОД БЭЛТГЭХ ЭРХИЙН БИЧИГ, МОД МОДОН МАТЕРИАЛЫН ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ЦАХИМААР ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. Үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь мод бэлтгэх, тээвэрлэх, худалдан борлуулах үйл ажиллагаанд ашиглагдах мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээг олгох, хяналт тавихад үүсэх харилцааг зохицуулна.

1.2.Энэ журам нь Монгол Улсын нутаг дэвсгэрт “Ойн тухай” хуульд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглана.

ХОЁР. Нэр томьёоны тодорхойлолт

2.1.Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.мод, модон материал цахим гарал үүслийн гэрчилгээ /цаашид “цахим гарал үүслийн гэрчилгээ” гэх/ гэж мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг ашиглаж аймаг, нийслэл, сум тэдгээрийн хооронд тээвэрлэх, худалдахад ойгоос зохих заавар, журмын дагуу бэлтгэсэн мод болохыг гэрчилж иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад олгосон баримт бичгийг.

2.1.2.“тээвэрлэгч” гэж тухайн мод, модон материалыг тээвэрлэж яваа иргэн, хуулийн этгээдийг;

2.1.3.“мод, модон материал” гэж гуалин, шургааг, зүсмэл материал /дүнз, дүнзэнцэр, банз, брус, дранк/ түлээг;

2.1.4.“цахим систем” гэж эрхийн бичиг болон гарал үүслийн гэрчилгээг ашиглах цахим хуудсанд суурилуулсан байнгын нэгдсэн мэдээллийг;

2.1.5.“бэлтгэх арга” гэж:

2.1.5.1.ойн төлөв байдалд сөргөөр нөлөөлж байгаа мод, бутыг огтлох замаар ой ургах тааламжтай орчныг бий болгоход чиглэсэн арчилгааны арга хэмжээ;

2.1.5.2.түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж хатсан, цаашид ургах чадваргүй болсон ойн модыг огтлох замаар ойг цэвэрлэх, ойг эрүүлжүүлэхэд чиглэгдсэн цэвэрлэгээний арга хэмжээ;

2.1.5.3.нас гүйцсэн модыг огтлох замаар модон түүхий эдийг бэлтгэхэд чиглэсэн үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолтыг.

ГУРАВ. Мод бэлтгэх цахим эрхийн бичиг олгох

3.1.Мод бэлтгэх цахим эрхийн бичгийг цахим системээр дамжуулан олгоно.

3.2.Цахим системийн ашиглалт, хөгжүүлэлт, техникийн үйл ажиллагаа, хэрэглэгчийн бүртгэл, өгөгдлийн нууцлал болон системийн аюулгүй байдлыг хангах үүрэг нь ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

3.3.Системийн нэвтрэх эрх, админ удирдлага, мэдээллийн хадгалалтыг тус байгууллага тогтоож мөрдүүлнэ.

3.4.Ойн анги эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан нь Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр тогтоосон тухайн жилийн дээд хязгаарт багтаан цахим эрхийн бичгийг олгоно.

3.5.Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойгоос мод бэлтгэх цахим эрхийн бичгийн хугацаа 24 цаг байх ба хугацааг сунгах хүсэлтийг нэг удаа гаргаж болох бөгөөд сунгалт олгосон ойн анги эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан холбогдох дүгнэлтийг цахим системд хавсаргана.

3.6.Эрхийн бичигт хэрэглээний модны эзлэхүүнийг нягт шоометр /м.куб/ -ээр, түлээний эзлэхүүнийг сийрэг шоометр /м.куб/ -ээр тооцно.

ДӨРӨВ. Мод модон материалыг тээвэрлэх цахим гарал үүслийн гэрчилгээ олгох

4.1.Цахим гарал үүслийн гэрчилгээг Ойн анги эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан цахим эрхийн бичиг заасан бэлтгэх хязгаарт багтаан цахим системээр дамжуулан олгоно.

4.2.Мод бэлтгэх эрхийн бичигт заасан нийт тоо хэмжээнд үндэслэж мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгоно.

4.3.Журмын 4.2-т олгосон тоо хэмжээ нь нийт батлагдсан хувиараас автоматаар хасагдана.

4.4.Ойн анги эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан цахим гарал үүслийн гэрчилгээг олгохдоо фото зургаар баталгаажуулж, цахим системд бүртгэнэ.

4.5.Мод, модон материалыг тээвэрлэх зайнаас хамаарч гарал үүслийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг Монгол Улсын батлагдсан авто замын сүлжээний километрээр тооцон 300 километр тутамд хоногийн 24 цагаар тооцон хүрэх цэг хүртэл цаг, минутыг бичнэ.

4.6.Мод, модон материалыг төмөр замаар тээвэрлэх тохиолдолд гарал үүслийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа 5 хоног байна.

4.7.Хүндэтгэх шалтгаантай тохиолдолд тухайн орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн /байгаль орчны хяналтын улсын байцаагч/-д хүсэлт гарган автомашинаар тээвэрлэж буй тохиолдолд Монгол улсын батлагдсан авто замын сүлжээний

километрээр тооцон 300 километр тутамд хоногийн 24 цагаар тооцон 1 удаа, төмөр замаар тээвэрлэж буй тохиолдолд 5 хоногийн хугацаатайгаар 1 удаа сунгана.

ТАВ. Цахим эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг тайлагнах

5.1.Ойн анги, сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан цахим эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголт, үлдэгдлийн тайланг улирал тутамд цахим системээс татан авч, улирал бүрийн эхний сарын 10-ны дотор дээд шатны Засаг дарга, ойн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад тайлагнана.

5.2.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь цахим эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголтын тайланг улирал бүрийн эхний сарын 10-ны дотор гаргана.

ЗУРГАА. Цахим эрхийн бичигт хяналт тавих

6.1.Мод бэлтгэсэн газраас үйлдвэрийн байр хүртэлх зайд мод тээвэрлэх үед мод бэлтгэх цахим эрхийн бичигтэй хамт хяналтын хуудас дагалдана. Байгаль хамгаалагч хяналтын хуудсыг хянаж, шалгасны үндсэн дээр зохих тэмдэглэгээг хийж тэмдэг дарж баталгаажуулан хуулбар хувийг өөртөө үлдээн бүртгэл хөтөлнө.

6.2.Мод бэлтгэх цахим эрхийн бичиг, хяналтын хуудас нь мод бэлтгэлийн улирал, жилийн гэрээг дүгнэхэд тооцооны эх материал болгон ашиглана.

6.3.Цахим эрхийн бичиг нь цахим гарал үүслийн гэрчилгээг орлохгүй.

6.4.Цахим эрхийн бичгийг хуурамчаар үйлдэх, хуулбарлах, олшруулах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

ДОЛОО. Цахим гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавих

7.1.Цахим гарал үүслийн гэрчилгээний бүрдэл, хүчинтэй хугацааг Ойн газар, байгаль орчны хяналтыг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтан, ойн асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч, цагдаагийн байгууллага хяналт тавина.

7.2.Тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч нь цахим эрхийн бичигт үндэслэн олгосон гарал үүслийн гэрчилгээг шалгасан тухай фото зургаар баталгаажуулж, цахим системд бүртгэнэ.

7.3.Шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн албан хаагч нь энэ журмын 7.2-т тулгалт хийж баталгаажуулна.

7.4.Төвлөрсөн суурин газар, Улаанбаатар хотын тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлэх цэг, төмөр замын ачаа буулгах газар захуудын дэргэдэх байгаль орчны хяналтын улсын байцаагч нь шалгаж баталгаажуулна.

7.5.Цахим гарал үүслийн гэрчилгээгүй, гэрчилгээг баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй мод, модон

материалыг зөвшөөрөлгүйгээр бэлтгэсэн гэж үзнэ.

7.6.Мод, модон материалын төрөлжсөн захаас мод, модон материал худалдан авч өөр аймаг, сум руу тээвэрлэхдээ цахим гарал үүслийн гэрчилгээний хуулбар, зарлагын баримтын хамтаар тээвэрлэнэ.

7.7.Мод, модон материал худалдан авагч нь цахим гарал үүслийн гэрчилгээгүй, мод, модон материалын талаарх мэдээллийг холбогдох эрх бүхий албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын
2026 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/794 дүгээр
тушаалын 2 дугаар хавсралт*

**Мод бэлтгэх цахим эрхийн бичгийн загвар
МОД БЭЛТГЭХ ЦАХИМ ЭРХИЙН БИЧИГ**

Дугаар
Сумын нэр Хэсэглэл, ялгарлын дугаар
Газрын нэр Модны төрөл
Мод бэлтгэх арга, огтлолтын төрөл
Мод бэлтгэгчийн нэр
/иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн
дугаар, утас/.....

№	Төрөл	Мод тээврийн зай /км/	Тоо хэмжээ /м3/	Ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласны төлбөр /төг/	
				1 м3 модны	Бүгд
1	Хэрэглээний мод				
2	Түлээний мод				
3	ДҮН				

Бэлтгэх хугацаа оны ... –р сарын ... –ээс хүртэл ... хоног.
Тээвэрлэх хугацаа ... оны –р сарын –ээс ... хүртэл ... хоног.
Мод бэлтгэх эрх олгосон:

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын
2026 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн
А/794 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт*

**Мод модон материалын цахим гарал үүслийн гэрчилгээний
загвар**

Дугаар

Аймгийн нэр: Сумын нэр

Эрхийн бичгийн дугаар Модны төрөл

Бэлтгэгчийн нэр, хаяг

/иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн
дугаар, утас/.....

№	Бэлтгэсэн арга	Мод, модон материалын нэр төрөл	Тээврийн зай /км/	Тоо хэмжээ /м3/
1	Хэрэглээний мод			
2	Түлээний мод			
3	Дүн			

Худалдан авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, хүргэх
газрын нэр

Зориулалт

Тээврийн хэрэгслийн марк, улсын /вагоны/дугаар:

Тээвэрлэсэн огноо: ... оны –р сарын-ны өдөр.

Хүчинтэй хугацаа:хоног.

Олгосон:

Баталгаажуулсан албан тушаалтан: /...../

Хянаж шалгасан:

... оны –р сарын -ны өдрийн цаг минут

Бэлтгэн нийлүүлэгч:

Сунгав:

... оны –р сарын -ны өдрийн цаг минут

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 6 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 9/4

Цогтцэций сум

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татварын жилд ногдуулах хэмжээг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 0 (тэг) төгрөгөөр тогтоосугай.

2.Батлагдсан тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн нарийн бичгийн дарга (Б.Ганболд)- д даалгасугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 5/7 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7/12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.ЭНХБААТАР



အိန္ဒိယနိုင်ငံ၏ အကျိုးအမြတ်ကို အကျိုးခံစားခွင့်ရှိသူများအား ခွဲဝေပေးရန် အရေးကြီးပါသည်။


[illegible]

ಪುನಃಪರಿಶೀಲನೆಗೆ ಒಳಪಟ್ಟು, 2026 ರ 6 ರಿಂದ 12 ರ ವರೆಗೆ

L

אם נחזיר

2026102106 22



2011 අගෝස්තු : ප්‍රභූතම ම/ ප්‍රසන්නප්‍රසාද්‍යාචාර්ය ම/ ප්‍රසන්නප්‍රසාද්‍යාචාර්ය .

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
МАНДАЛ-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 8/01

Мандал-Овоо сум

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАР
ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Мандал-Овоо сумын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойн албан татварын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоосон тогтоолыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ж.Байгаль)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 3/01 дүгээр тогтоол, Мандал-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн тогтоолд өөрчлөлт оруулах тухай 16/01 дүгээр тогтоолоор хавсралтад өөрчлөлт оруулсаныг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.СҮХБААТАР

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
8/01 дүгээр тогтоолын хавсралт*

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

Малын төрөл	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Нэг малд ноогдох албан татварын хэмжээ	200	200	200	300	400

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

ХЭНТИЙ АЙМГИЙН “ХЭНТИЙ УС” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн “Хэнтий ус” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Хэнтий ус” ХХК /Д.Хүрэлбаатар/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Хэнтий ус” ХХК /Д.Хүрэлбаатар/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 82 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, 2019 оны 65 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, 2023 оны 90 дүгээр тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮН

Г.ЦОГТСАЙХАН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07 дугаар сарын 21-ний
өдрийн 97 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ХЭНТИЙ АЙМГИЙН “ХЭНТИЙ УС” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	3.00
	Тоолуургүй	төг/л	4.00
Бохир ус	Тоолууртай	төг/л	3.05
	Тоолуургүй	төг/л	4.20
Ус түгээх байр		төг/л	3.63

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Үйлдвэр ААНБ-тоолууртай	төг/л	4.80
	Үйлдвэр ААНБ-тоолуургүй	төг/л	5.50
	Төсөвт байгууллага	төг/л	5.50
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	5.50
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	4.80
	Үйлдвэр ААНБ зөөврөөр	төг/л	10.00
Бохир ус	Үйлдвэр ААНБ-тоолууртай	төг/л	5.00
	Үйлдвэр ААНБ-тоолуургүй	төг/л	5.75
	Төсөвт байгууллага	төг/л	5.75
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	5.75
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	5.20
	Зөөвөрлөх	төг/л	18.00
	Зөөвөр/хүлээн авах/	төг/л	40.00

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 07-р сарын 21-ний өдрийн
97 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ХЭНТИЙ АЙМГИЙН “ХЭНТИЙ УС” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 7683 дугаарт бүртгэгд

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 8 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН “УНДАРГА-АЛТАЙ” ААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ, СУУРЬ ХУРААМЖ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “Ундарга-Алтай” ААТҮГ /Э.Энхболд/-т үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Ундарга-Алтай” ААТҮГ /Э.Энхболд/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 87, 2019 оны 86, 2021 оны 71 дүгээр тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 101 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН “УНДАРГА-АЛТАЙ” ААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	2.50
	Тоолуургүй	төг/л	3.50
Бохир ус	Тоолууртай	төг/л	2.00
	Тоолуургүй	төг/л	2.50
Ус түгээх байр		төг/л	4.00

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Үйлдвэр ААНБ-тоолууртай	төг/л	7.00
	Төсөвт байгууллага	төг/л	15.00
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	14.00
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	7.00
	Үйлдвэр ААНБ зөөврөөр	төг/л	18.00
Бохир ус	Үйлдвэр ААНБ-тоолууртай	төг/л	5.00
	Төсөвт байгууллага	төг/л	13.00
	Спирт, архи, пиво, усны үйлдвэр, мах, сүү, талх нарийн боов, эмнэлэг	төг/л	12.00
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, машин угаалга	төг/л	6.00
	Зөөврөөр бохир ус татан зайлуулах	төг/л	18.00

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 04-ний
өдрийн 101 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН “УНДАРГА-АЛТАЙ” ААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 8 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

ТӨВ АЙМГИЙН “ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төв аймгийн “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ /Д.Баярбат/-т үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ /Д.Баярбат/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2021 оны 58 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, Зохицуулах хорооны 2024 оны 38 дугаар тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татнуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 103 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨВ АЙМГИЙН “ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Зуунмод сумын-Тоолууртай	төг/л	2.00
	Зуунмод сумын-Тоолуургүй	төг/л	3.30
	Бүрэн сумын-Тоолууртай	төг/л	0.85
	Бүрэн сумын-Тоолуургүй	төг/л	1.10
Бохир ус	Зуунмод сумын-Тоолууртай	төг/л	2.00
	Зуунмод сумын-Тоолуургүй	төг/л	3.30
	Бүрэн сумын-Тоолууртай	төг/л	0.85
	Бүрэн сумын-Тоолуургүй	төг/л	1.10
Ус түгээх байр		төг/л	2.00

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Зуунмод сумын -Дор дурдсанаас бусад Үйлдвэр ААНБ	төг/л	6.00
	Зуунмод сумын-Төсөвт байгууллага	төг/л	8.50
	Зуунмод сумын-Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	10.00
	Бүрэн сумын-Дор дурдсанаас бусад Үйлдвэр ААНБ	төг/л	4.00
	Бүрэн сумын-Төсөвт байгууллага	төг/л	4.50
Бохир ус	Зуунмод сумын -Дор дурдсанаас бусад Үйлдвэр ААНБ	төг/л	7.00
	Зуунмод сумын-Төсөвт байгууллага	төг/л	8.50
	Зуунмод сумын- Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга;	төг/л	10.00
	Бүрэн сумын-Дор дурдсанаас бусад Үйлдвэр ААНБ	төг/л	5.00
	Бүрэн сумын-Төсөвт байгууллага	төг/л	5.00

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 04-ний
өдрийн 103 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ТӨВ АЙМГИЙН “ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 7685 дугаарт бүртгэв

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 8 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

ЗАВХАН АЙМГИЙН “АМЬ-УС” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн “Амь-Ус” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Амь-Ус” ХХК /Д.Мягмардорж/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Амь-Ус” ХХК /Д.Мягмардорж/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2012 оны 184, Зохицуулах хорооны 2023 оны 129, 2024 оны 103 дугаар тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 104 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**ЗАВХАН АЙМГИЙН “АМЬ-УС” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	тоолууртай	төг/л	1.5
	тоолуургүй	төг/л	1.7
	Ус түгээх байр	төг/л	2.7
Бохир ус	тоолууртай	төг/л	1.5
	тоолуургүй	төг/л	1.7

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	төг/л	7.5
	Төсөвт байгууллага	төг/л	7.5
	Спирт, архи пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	8.5
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	8.5
Бохир ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	төг/л	7.5
	төсөвт байгууллага	төг/л	7.5
	Спирт, архи пиво, усны үйлдвэр, мах, сүү, талх нарийн боов, эмнэлэг	төг/л	8.5
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	8.5
	Зөөврөөр	төг/л	20.0

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08-р сарын 04-ний өдрийн
104 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ЗАВХАН АЙМГИЙН “АМЬ-УС” ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)
тоолууртай хэрэглэгчийн**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 8 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 110

Улаанбаатар
хот

СЭЛЭНГЭ АЙМГИЙН “ЦАНТ-ОРХОН” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ, СУУРЬ ХУРААМЖ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн “Цант-Орхон” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “Цант-Орхон” ОНӨААТҮГ /Ц.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Цант-Орхон” ОНӨААТҮГ / Ц.Лхагвасүрэн /-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2019 оны 92, Зохицуулах хорооны 2024 оны 117 дугаар тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 24-ний
өдрийн 110 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН “ЦАНТ-ОРХОН” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Ус түгээх байр	төг/л	3.64
Бохир ус	Айл өрх /тоолууртай/	төг/л	1.70
	Айл өрх /тоолуургүй/	төг/л	2.50

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Бохир ус	Үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллага тоолууртай	төг/л	3.50
	Төсөвт байгууллага	төг/л	4.90
	Спирт, архи, пиво, усны үйлдвэр, мах, сүү, талх нарийн боов, эмнэлэг	төг/л	4.00
	Барилга, ашиглалт үйлчилгээний 1-р анги	төг/л	1.70
	Зөөврөөр /айл өрх/	төг/л	15.60
	Зөөврөөр /ААНБ/	төг/л	18.20
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хорих 413-р анги	төг/л	9.00

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 24-ний
өдрийн 110 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН “ЦАНТ-ОРХОН” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 7687 дугаарт бүртгэв

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2026 оны 8 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 123

Улаанбаатар
хот

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН “СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ, СУУРЬ ХУРААМЖ
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, ажиллахыг “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ /Э.Эрдэнэсайхан/-т үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ /Э.Эрдэнэсайхан/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах хорооны 2023 оны 57 дугаар тогтоолыг заасан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 123 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН “СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	2.10
	Тоолуургүй	төг/л	2.35
	Ус түгээх байр	төг/л	3.64
Зөөврөөр		төг/л	9.00
Бохир ус	Тоолууртай	төг/л	2.21
	Тоолуургүй	төг/л	2.50

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	5.80
	Төсөвт байгууллага	төг/л	7.20
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	7.00
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	6.50
Бохир ус	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	8.00
	Төсөвт байгууллага	төг/л	8.50
	Спирт, архи, пиво, усны үйлдвэр, мах, сүү, талх, нарийн боов, эмнэлэг	төг/л	8.00
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, машин угаалга	төг/л	8.00
Зөөврөөр бохир ус татан зайлуулах		төг/л	35.00

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 08-р сарын 24-ний өдрийн
123 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН “СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
10.	150	156,600	37,800
11.	400=<	576,000	115,200

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 7 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 12/31

Номгон

**ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН
ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн 20 сумын хамгаалалтад байх 276 дурсгалт газрын 1143 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг аймгийн Засаг дарга (Э.Энхбат)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, хяналт шинжилгээний хороо (Д.Ууганцэцэг), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Б.БАТСУУРЬ

Энэ тогтоолын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17438754455682&showType=1>

၂၀၁၇ ခုနှစ် ဇူလိုင်လ ၁ ရက်နေ့
 မြန်မာနိုင်ငံတော် အစိုးရတော်

ՅԵՏԱՌԻՄՈՒԹՅՈՒՆ ԻՆՏԵՐՆԱԼ ՈՒ ԿԱՌԱՐԱՆԱԿԱՆ ԳԵՐԵՆՈՒՄԻՆԵՐԱԼ ՈՒ ՏՈՒՆՆԱԿԱՆ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам батлах тухай” 07 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, санхүүжүүлэх журам”-д доор дурдсан агуулгатай дараах хэсгийг нэмсүгэй:

1.1. Журмын тав дахь хэсгийн 5.4.3 дахь дэд заалт, найм дахь хэсгийн 1.2 дахь заалтын 8 дахь дэд заалтад тус тус **“Энэ заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө”**

2. Энэ тогтоолыг баталсантай холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 100 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам” болон Монгол Улсын Засгийн газрын 2026 оны “Эрүүл мэндийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 134 дүгээр тогтоолд заасны дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн яам /Н.Эрдэнэбаяр/-нд даалгасугай:

2.1. “Эрүүл мэндийн салбарын мэдээллийн солилцооны систем” болон “Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан”-г байгуулж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж эхлүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;

2.2. Эрүүл мэндийн салбарын программ хангамж хөгжүүлэгч, нийлүүлэгч байгууллагуудаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний

программ хангамжийн хөгжүүлэлт, мэдээллийн сүлжээний холболт, ашиглалт үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах;

2.3.Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, сувилагч, бүртгэлийн ажилтнуудад даатгуулагчийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас илгээх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, арга зүйгээр хангаж ажиллах.

3.Энэ тогтоолыг баталсантай холбоотой Даатгуулагчийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн байхыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл шаардахгүй байх тохируулга, өөрчлөлтийг эрүүл мэндийн даатгалын цахим системд оруулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Ц.Батбаатар/-т даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбоотой тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Ц.Сарантуяа/-нд, энэ тогтоолын 2 дахь заалтын хэрэгжилтийн бэлэн байдлыг үнэлж, үр дүн, явцын тайланг 2026 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд танилцуулахыг Эрүүл мэндийн яам /Н.Эрдэнэбаяр/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Э.БАТШУГАР

ТЭМДЭГЛЭЛ